

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНД ИМПОРТЛОХ ҮРИЙН УЛААНБУУДАЙН ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам", Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2022 онд импортлох үрийн улаанбуудайн тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Стратегийн хүнсийг импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Алтансүх)-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д тус тус даалгасугай.

3.Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

САЙД З.МЭНДСАЙХАН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2022 оны 04 дүгээр сарын 04 -ны өдрийн
А/113 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНД ИМПОРТЛОХ ҮРИЙН УЛААНБУУДАЙН
ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Тоо хэмжээ
1	Улаанбуудай	Улаанбуудай /үрийн/	1001.11.00 1001.91.10	5,000 тн (таван мянга)